



# **“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК**

*(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)*

**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**  
**2023 оны 12 дугаар сарын 31**


Улаанбаатар 2024

# “ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК -ийн Гүйцэтгэх захирал Х.Тэгшээ, Ерөнхий нягтлан бодогч Д.Бат-Ирээдүй бид, энэхүү тайлангийн 5-34 дүгээр хуудсанд тусгагдсан Компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (СТОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч батлав.



ХАРХҮҮ ОВОГТОЙ ТЭГШЭЭ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ДААРИЙМАА ОВОГТОЙ БАТ-ИРЭЭДҮЙ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2024 оны 5 дугаар сарын 27 өдөр



ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюдинг, #602 тоот,  
Жамъяан гүний гудамж -18/1,  
I дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот-14240, Монгол улс

Утас: +976-75057979

Факс: +976-70186131

Имэйл: [info@pkf.mn](mailto:info@pkf.mn)

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

Ref: 09/MGLA/23/14/05122023/EN

Толгойгын баруун салаа, 19-4 тоот,  
Бумбатын ам, 7 -р хороо,  
Сонгинохайрхан дүүрэг-18151,  
Улаанбаатар хот, Монгол улс

Имэйл: [finance@mglacqua.mn](mailto:finance@mglacqua.mn)

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

### Дүгнэлт

Бид “ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК (цаашид “Компани” гэх) –ийн 2023 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

### Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (Үргэлжлэл)

"ЭМ ЖИ ЭЛ АКУА" ХХК -ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

### Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА

Гүйцэтгэх захирал

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2024 оны 5 дугаар сарын 27 өдөр

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид



**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 БОЛОН 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 –НИЙ ӨДРӨӨ

| <i>(төгрөгөөр)</i>                      |     |                          |                          |
|---|-----|--------------------------|--------------------------|
| ҮЗҮҮЛЭЛТ                                | СТТ | 2022.12.31               | 2023.12.31               |
| <b>ХӨРӨНГӨ</b>                          |     |                          |                          |
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |     |                          |                          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 2   | 41,910,529.74            | 88,745,994.04            |
| Дансны авлага                           | 3   | 1,040,383,008.79         | 1,406,756,156.87         |
| Татвар, НДШ -ийн авлага                 | 4   | -                        | 342,439,852.85           |
| Бусад авлага                            | 5   | 9,470,983,145.48         | 3,344,646,393.05         |
| Бараа материал                          | 6   | 2,166,463,547.49         | 2,430,479,532.11         |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо         | 7   | 11,225,575,299.24        | 9,075,111,825.70         |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          |     | <b>23,945,315,530.74</b> | <b>16,688,179,754.62</b> |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |     |                          |                          |
| Үндсэн хөрөнгө                          | 8   | 2,908,097,329.53         | 16,204,523,842.10        |
| Биет бус хөрөнгө                        | 9   | 4,992,227.90             | 1,156,535,000.00         |
| Дуусаагүй барилга                       | 10  | 1,086,884,231.00         | -                        |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      |     | <b>3,999,973,788.43</b>  | <b>17,361,058,842.10</b> |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               |     | <b>27,945,289,319.17</b> | <b>34,049,238,596.72</b> |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |     |                          |                          |
| <b>ӨР ТӨЛБӨР</b>                        |     |                          |                          |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>        |     |                          |                          |
| Дансны өглөг                            | 11  | 5,980,685,223.37         | 28,035,387.94            |
| Татвар хураамжийн өр төлбөр             | 12  | 1,529,921,912.09         | 1,347,676,398.25         |
| НДШ -ийн өр төлбөр                      | 13  | 148,100,934.17           | 117,395,136.83           |
| Богино хугацаат зээл                    | 14  | 1,378,946,391.98         | 7,000,000,000.00         |
| Урьдчилж орсон орлого                   | 15  | 36,875,923.02            | 57,848,824.29            |
| Бусад богино хугацаат өр төлбөр         | 16  | 6,380,585,402.70         | 3,168,506,259.30         |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> |     | <b>15,455,115,787.33</b> | <b>11,719,462,006.61</b> |
| <b>Урт хугацаат өр төлбөр</b>           |     |                          |                          |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн           |     | -                        | -                        |
| <b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>            |     | <b>15,455,115,787.33</b> | <b>11,719,462,006.61</b> |
| <b>ЭЗДИЙН ӨМЧ</b>                       |     |                          |                          |
| Хувийн өмч                              | 17  | 573,567,609.68           | 600,000,000.00           |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 18  | -                        | 7,100,613,377.98         |
| Хуримтлагдсан ашиг                      | 19  | 11,916,605,922.16        | 14,629,163,212.13        |
| <b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>                |     | <b>12,490,173,531.84</b> | <b>22,329,776,590.11</b> |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   |     | <b>27,945,289,319.17</b> | <b>34,049,238,596.72</b> |

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

**АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| ҮЗҮҮЛЭЛТ  | СТТ       | (төгрөгөөр)              |                          |
|---|-----------|--------------------------|--------------------------|
|   |           | 2022                     | 2023                     |
| <b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)</b>                        | <b>20</b> | <b>33,351,223,920.53</b> | <b>20,055,361,034.31</b> |
| Борлуулалтын өртөг  | 20        | 20,331,676,083.27        | 10,183,545,473.75        |
| <b>НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)</b>                               |           | <b>13,019,547,837.26</b> | <b>9,871,815,560.56</b>  |
| Хүүний орлого   | 21        | -                        | 661,443.75               |
|   |           | -                        | <b>661,443.75</b>        |
| Борлуулалт маркетингийн зардал                            | 22        | 18,269,134.51            | 38,790,948.46            |
| Ерөнхий ба удирдлагын зардал                              | 23        | 7,228,769,885.13         | 5,086,139,706.54         |
| Санхүүгийн зардал   | 24        | 274,250,295.03           | 1,182,686,480.63         |
| Бусад зардал  | 24        | 59,036,571.10            | 429,560,596.07           |
|   |           | <b>7,580,325,885.77</b>  | <b>6,737,177,731.70</b>  |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз)          | 25        | 422,445,519.67           | -                        |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз)      | 25        | -                        | 802,692.20               |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                | 26        | -                        | (37,456,547.81)          |
| Бусад ашиг (алдагдал)                                     | 26        | -                        | (137,665,866.75)         |
|   |           | <b>422,445,519.67</b>    | <b>(174,319,722.36)</b>  |
| <b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)</b>              |           | <b>5,861,667,471.16</b>  | <b>2,960,979,550.25</b>  |
| Орлогын татварын зардал                                   | 27        | 599,000,404.22           | 371,016,616.46           |
| <b>ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)</b>                   |           | <b>5,262,667,066.94</b>  | <b>2,589,962,933.79</b>  |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) |           |                          |                          |
| <b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)</b>                |           | <b>5,262,667,066.94</b>  | <b>2,589,962,933.79</b>  |
| БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО                                  |           | -                        | -                        |
| <b>ОРЛОГЫН НИЙТ ДҮН</b>                                   |           | <b>5,262,667,066.94</b>  | <b>2,589,962,933.79</b>  |

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

**ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| ҮЗҮҮЛЭЛТ   | Өмч                   | Хөрөнгийн дахин<br>үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан<br>ашиг    | Нийт дүн<br>(тегергээр)  |
|--|-----------------------|--|--------------------------|--------------------------|
| <b>2021 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл</b>           | <b>573,567,609.68</b> | -                                      | <b>6,653,938,855.22</b>  | <b>7,227,506,464.90</b>  |
| НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |                       |  | 6,657,382.61             | 6,657,382.61             |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                 | <b>573,567,609.68</b> | -                                      | <b>6,660,596,237.83</b>  | <b>7,234,163,847.51</b>  |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                        |                       |  | 5,262,667,066.94         | 5,262,667,066.94         |
| <b>2022 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл</b>           | <b>573,567,609.68</b> | -                                      | <b>11,923,263,304.77</b> | <b>12,496,830,914.45</b> |
| НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |                       |  | -                        | -                        |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                 | <b>573,567,609.68</b> | -                                      | <b>11,923,263,304.77</b> | <b>12,496,830,914.45</b> |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                        |                       |  | 2,589,962,933.79         | 2,589,962,933.79         |
| Өмчид гарсан өөрчлөлт                                      | 26,432,390.32         | 7,245,919,674.13                       | -                        | 7,272,352,064.45         |
| Зарласан ногдол ашиг                                       | -                     | -                                      | (29,369,322.58)          | (29,369,322.58)          |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                  | -                     | (145,306,296.15)                       | 145,306,296.15           | -                        |
| <b>2023 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл</b>           | <b>600,000,000.00</b> | <b>7,100,613,377.98</b>                | <b>14,629,163,212.13</b> | <b>22,329,776,590.11</b> |



Хаасаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| ҮЗҮҮЛЭЛТ  | (төгрөгөөр)               |                           |
|---|---------------------------|---------------------------|
|   | 2022.12.31                | 2023.12.31                |
| <b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                          |                           |                           |
| <b>Тайлант жилийн ашиг (алдагдал)</b>                                 | <b>5,262,667,066.94</b>   | <b>2,589,962,933.79</b>   |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                    | 229,674,577.14            | 833,430,133.06            |
| Бусад мөнгөн бус зардал   | -                         | 503,286,306.55            |
| Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)                            | -                         | (802,692.20)              |
| Авлагын өсөлт, бууралт  | (4,179,210,073.62)        | 5,417,523,751.50          |
| Урьдчилж төлсөн зардал/тооцооны бууралт (өсөлт)                       | 1,845,167,685.50          | 2,150,463,473.54          |
| Бараа материалын өсөлт, бууралт                                       | (859,836,070.29)          | (264,015,984.62)          |
| Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, (бууралт)                         | 575,052,326.00            | (9,434,366,106.54)        |
| Орлогын албан татварын зардал   | 599,000,404.22            | 371,016,616.46            |
| Төлсөн орлогын албан татвар   | (429,216,597.88)          | (293,291,753.72)          |
| <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>3,043,299,318.01</b>   | <b>1,873,206,677.82</b>   |
| <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>              |                           |                           |
| Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт                     | (1,724,644,200.00)        | (3,461,263,158.38)        |
| Хүлээн авсан хүүний орлого  |                           | 661,443.75                |
| Бусад олгосон зээл урьдчилгаа   |                           | (3,986,823,106.91)        |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>(1,724,644,200.00)</b> | <b>(7,447,424,821.54)</b> |
| <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                      |                           |                           |
| Хүлээн авсан зээл болон өр төлбөр                                     | 633,870,725.00            | 7,613,348,375.50          |
| Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт                                  | (1,954,924,332.03)        | (1,992,294,767.48)        |
| Валютын ханшийн зөрүү   | 23,060,231.59             | -                         |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         | <b>(1,297,993,375.44)</b> | <b>5,621,053,608.02</b>   |
| <b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                       | <b>20,661,742.57</b>      | <b>46,835,464.30</b>      |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                      | 21,248,787.17             | 41,910,529.74             |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                     | 41,910,529.74             | 88,745,994.04             |

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

